



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 1/21

Мандалговь

"Шүлхий" өвчний вакцинжуулалтыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, 4.5.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малын гоц халдварт "Шүлхий" өвчин гарч зарим сумдыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаа тул мал сүргийг вакцинжуулалтанд хамруулах ажлыг 2017 оны 8 дугаар сарын 11-ээс эхлэн шуурхай зохион байгуулахыг Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан, Хулд, Луус, Өндөршил сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Шүлхийн вакцинжуулалтад хяналт тавих онцгой комиссын гишүүдийг 1-р хавсралтаар, вакцины хуваарийг 2-р хавсралтаар баталсугай.

Гурав. Захирамжийн биелэлтийг хангуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б.Мөнхжаргал/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Онцгой комиссын орлогч дарга /Я.Алтанхундага/ -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

0200778